

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2016-2017 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

АГУУЛГА

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2014 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, 2015-2017 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ.....	3
1.1 Дэлхийн эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл.....	3
1.2 БНХАУ-ын эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл	3
1.3 Монгол улсын эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл	4
ДНБ-ий 2013 оны гүйцэтгэл, 2014 оны төсөөлөл	4
Инфляци	7
Гадаад худалдаа	9
Төлбөрийн тэнцэл	12
Ажилгүйдэл	13
2. ДУНД ХУГАЦААНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ	14
3. МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	14
4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2014 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	17
5. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015-2017 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ.....	19
5.1 ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	19
5.2 ТӨСВИЙН ОРЛОГО	19
5.3 ТӨСВИЙН ЗАРЛАГА	23
5.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР.....	25
5.5 БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР, ТҮҮНИЙ ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭ.....	28
5.6 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ.....	28
6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦСЭН БАЙДАЛ.....	28
7. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ТӨСВИЙН БОДЛОГЫН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААР ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	30
8. ДУНД ХУГАЦААНД ТӨСӨВТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД.....	33
9. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХОД ХЭРЭГЛЭСЭН АРГАЧЛАЛ, ТООЦООНЫ ҮНДЭСЛЭЛ.....	34


1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2014 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, 2015-2017 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

1.1 Дэлхийн эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2013 онд бага зэрэг саарч, 3 хувиар өссөн бөгөөд үүнд өндөр хөгжилтэй орнууд төдийгүй, хөгжиж байгаа орнуудын эдийн засаг ч саарав. АНУ-ын Холбооны нөөцийн сан 2012 оны 9 дүгээр сараас эхлэн сар бүр 85 тэрбум ам.долларын бонд худалдан авах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2013 оны 5 дугаар сард тус нөөцийн сангаас бонд худалдан авах хэмжээгээ багасгахаар мэдэгдсэнээр олон улсын зах зээлд голлох түүхий эдийн үнэ ханш буурч эхэлсэн. Үүнтэй зэрэгцээд дэлхий даяар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 6 хувиар буурав.

Дэлхийн эдийн засгийн байдал 2015-2017 онд өмнөх жилүүдээс харьцангуй сайжрах төлөвтэй бөгөөд үүнээс АНУ болон Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2015-2017 онд бага зэрэг нэмэгдэх хандлагатай байгаа бол БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 7.3-7.4 хувьд хүрч бага зэрэг буурахаар байна.

График. Голлох улсуудын эдийн засгийн өсөлтийн таамаглал¹



Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2014 оноос Евро бүсийн зүгээс санхүүгийн зах зээлийг чадавхижуулах, эдийн засгийн нийт эрэлтийг дэмжих, бүтээгдэхүүний болон хөдөлмөрийн зах зээлийг шинэчлэх, эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгоход чиглэн хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний үр дүнд 1.0 хувиар өсөх хандлагатай байгаа нь дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд эерэг нөлөөллийг үзүүлэхээр байна. Улмаар Евро бүсийн эдийн засаг 2015 онд 1.4 хувьд хүрч өсөхөөр байна.

1.2 БНХАУ-ын эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл

ОУВС-ийн 2014 оны 1 дүгээр сарын байдлаарх таамаглалаар БНХАУ-ын эдийн засгийн эрчимтэй өсөлт саарах төлөвтэй байна. Экспортын гол түнш орон болох БНХАУ-ын эдийн засаг өсөлт саарах нь тус орны импортын эрэлт буурч, улмаар манай орны экспортын хэмжээ буурахад нөлөөлөх боломжтой.

Хүснэгт. БНХАУ, ОХУ-ын эдийн засгийн өсөлт

Улс	2012	2013	2014*	2015*
БНХАУ	7.7	7.7	7.5	7.3
ОХУ	3.4	1.5	2.0	2.5

Эх үүсвэр: "World economic outlook" 2014 оны 1 сар, ОУВС

¹ ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдал тайлан, 2014 оны 1 дүгээр сар

Харин ОХУ-ын хувьд эдийн засгийн өсөлт цаашид эрчимжих төлөвтэй гэж үзсэн байна. Энэ нь манай оронд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтад эерэг нөлөөлөх юм.

1.3 Монгол улсын эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл

ДНБ-ий 2013 оны гүйцэтгэл, 2014 оны төсөөлөл

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2013 онд саарсан болон дэлхий даяар гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан зэрэг өөрчлөлтийн улмаас Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлт 2013 онд 4.5 хувиар, үүнээс экспортын орлого 2.6 хувиар, импорт 5.7 хувиар тус тус буурсан. Оюутолгойн хөрөнгө оруулалтын эхний үе шат дуусч, хоёр дахь үе шатны хөрөнгө оруулалт тодорхойгүй байгаа, нөгөө талаар дээр дурдсанаар дэлхий даяар гадаадын хөрөнгө оруулалт буурсаны улмаас Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистик мэдээллээр гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2013 онд 54 хувиар буураад байна.

Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт буурсан хэдий ч дэлхийн зах зээлээс 2012 оны сүүлээр 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг босгосноор дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн өндөр өсөлтийг хадгалах боломж бүрдэж, Монгол Улсын ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 11.7 хувь болсон.

График. Монгол Улсын ДНБ-ий хэмжээ, өсөлтийн хувь /их наяд төгрөг/



Эх үүсвэр: ЭЗХЯ

Чингис бонд болон Хөгжлийн банкны хөрөнгөөр 1.7 их наяд төгрөг, Улсын нэгдсэн төсвөөр 1.2 их наяд төгрөг (улсын төсвийн хөрөнгөөр 790 тэрбум төгрөг)-ийн хөрөнгө оруулалт хийсэн нь 2012 оны улсын нэгдсэн төсөв, Хөгжлийн банкаар хийсэн хөрөнгө оруулалтаас 1.5 дахин их хэмжээ юм. Түүнчлэн, Монголбанкны зүгээс эдийн засгийн өсөлтийг дэмжиж, зарим бараа, бүтээгдэхүүний үнийн хэт өсөлтийг тогтворжуулах хүрээнд "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр", "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр" зэргийг хэрэгжүүлж, нийтдээ 3 орчим их наяд төгрөгийг арилжааны банкаар дамжуулан олгосон.

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэд бүтэц, бүтээн байгуулалт, барилга угсралтын ажлыг 2013 онд эрчимтэй өрнүүлсэнээр барилгын салбар 80 хувиар өсч, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэв. Цаг агаар харьцангуй тааламжтай байж, малчдын хөдөлмөр, зүтгэлийн үр дүнд 2013 онд 14 сая төл бойжуулж, мал сүргийн тоо толгой 45 саяд хүрсэн. Ингэснээр мал аж ахуйн салбар нийтдээ 16 хувиар өсөв.

Дэлхийн зах зээл, гадаад орчин тааламжтай байгаагүй ч уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчны зарим өөрчлөлт, холбогдох шийдвэрийг УИХ, Засгийн газар шуурхай гаргаж, бодлогоор дэмжиж ажилласны үр дүнд тус салбарын үйлдвэрлэл 2013 онд 20 хувиар өссөн.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2013 онд 22 хувиар өсч, 6 сая төгрөг буюу 3.9 мянган ам.долларт хүрээд байна.

Эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалах зорилтыг 2014 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд Чингис бонд, Хөгжлийн банкнаас оруулах хөрөнгө оруулалтаас гадна экспортын орлогыг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, Тавантолгойн нүүрсний бүлэг орд дээр олборлолт явуулж байгаа компаниудын үйл ажиллагааг уялдуулах, экспортыг нэгдсэн байдлаар зохион байгуулах, нүүрс угаах үйлдвэрт бусад компаниудын нүүрсийг боловсруулж, тээврийн зардлыг бууруулах, үнэ өртгийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээд байна. Боомтын төмөр замыг 2014 онд барьж дуусгах, зарим боомтыг байнгын ажиллагаатай болгож, ажиллах цагийг уртасгах, төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр болон барилгын арматурын үйлдвэрийг санхүүжилтээр дэмжих, Тавантолгой-Гашуун сухайтын хатуу хучилттай авто замын тарифыг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. БНХАУ-д нүүрс урт хугацаанд тогтвортой нийлүүлэх чиглэлээр гэрээ хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

Алтны олборлолтыг дэмжих, хууль бус алтны олборлолт, худалдааг багасгаж, Монголбанкны валютын нөөцийг нэмэгдүүлэх үүднээс УИХ 2014 оны 1 дүгээр сард 2019 он хүртэлхи хугацаанд алтны олборлолтод ногдох нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувь болгож, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийг хүчингүй болгосон. Мөн Монголбанкнаас хөнгөлөлттэй зээлийг алт олборлогчдод олгохоор төлөвлөж байна. Ингэснээр алт олборлолтын хэмжээ 2014-2019 онд эрчимтэй өсч, Монгол Улсын гадаад валютын нөөц нэмэгдэх юм.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нэг гол төрөл болох Концессийн зүйлийн жагсаалтыг 2013 онд шинэчлэн баталсан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд 2014 онд авто зам, цахилгаан станц, боловсролын салбарт нилээд олон төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын барилгын ажлын үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.

Гадаад орчны эдгээр эрсдлүүд байгаа хэдий ч дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2014 онд аж үйлдвэрийн салбар 18 хувиар, үүнээс уул уурхайн салбар 25 хувиар, барилгын салбар 15 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбар 10 хувиар тус тус өсөхөөр хүлээгдэж байна. Аж үйлдвэрийн салбар, барилга угсралт бүтээн байгуулалтын ажлын үр дүнд үйлчилгээний салбар 10 орчим хувиар өсөх төлөвтэй байна. Ингэснээр Монгол Улсын ДНБ 2014 онд 11.2 хувиар өсөхөөр байна.

ДНБ-ий 2015 оны зорилт, 2016-2017 оны хандлага

Дэлхийн болон худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн төлөв байдал, дотоод орчны нөхцөл байдлыг харгалзан үзэж, 2015 онд хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалахыг зорьж байна.

График. ДНБ-ий хэмжээ /их наяд төгрөг/ болон өсөлт/ хувиар/



Эх үүсвэр: ЭЗХЯ

Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн эрэлт 2015-2017 онд хурдтай сэргэх хандлага байхгүй байгаа тул худалдааны гол түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, экспортын бүтээгдэхүүнээ тогтвортой нийлүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатай байна. Энэ хүрээнд БНХАУ-тай нүүрс урт хугацаанд тогтвортой нийлүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар идэвхитэй ажиллаж байгаа бөгөөд эхний ээлжинд тус чиглэлээр санамж бичиг байгуулсан ба цаашлаад гэрээ, хэлэлцээр байгуулах талаар ажиллаж байна. Үүний үр дүнд ирэх жилүүдэд нүүрсний экспорт тогтвортой нэмэгдэнэ гэж төсөөлж байна. Түүнчлэн, ДЦС-3 болон ДЦС-4-ийн өргөтгөл, шинээр баригдаж байгаа бусад дулааны болон цахилгаан станцуудын нүүрсний хэрэглээ нэмэгдэх юм.

УИХ-аас алтны хууль бус олборлолт, худалдааг багасгаж, олборлолтыг нэмэгдүүлэн, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор тус бүтээгдэхүүнд ногдох нөөц ашигласны төлбөрийг бууруулсан. Ингэснээр алтны олборлолт ирэх жилүүдэд эрчимтэй нэмэгдэх боломжтой юм.

Уул уурхайн салбарын гадаад зах зээлийн хандлага, тус салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн үйлдвэрлэл зэргийн харгалзан үзвэл 2015 онд тус салбар 21 хувиар, 2016-2017 онд 5-14 хувиар өсөхөөр төсөөлж байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарыг дэмжих хүрээнд 2014 онд Чингис бонд болон бусад эх үүсвэрээр экспортод чиглэсэн, импортыг орлох үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулж байна. Эдгээр төслүүдэд барилгын материал, нэхмэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг багтаж байгаа юм. Үйлдвэржилтийг дэмжих бодлогын хүрээнд үйлдвэржилтэд шаардлагатай санхүүгийн тогтолцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч, экспортын болон зээлийн эрсдлийг даатгах даатгалын компани байгуулахаар төлөвлөж байна. Ингэснээр боловсруулах аж үйлдвэрийн салбар жилд 10 орчим хувиар өсөхөөр төсөөлж байна. Тус салбарыг болон эдийн засгийн өсөлтийг дэмжсэн санхүүгийн тогтолцоог бүрдүүлж чадсанаар эдгээр салбарууд хөгжихөөс гадна санхүүгийн зах зээл, санхүүгийн салбарын үйлчилгээ хөгжих боломжтой. Шинэ төмөр замын эхний хэсэг болох Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр зам 2015 онд ашиглалтад орж, төмөр замын тээвэрлэлт ирэх жилүүдэд хурдтай нэмэгдэнэ гэж тооцоолж байна. Аж үйлдвэр, барилга, тээвэр гэсэн эдийн засгийн голлох салбаруудын өсөлтийн үр дүнд худалдааны салбар болон бусад үйлчилгээний салбаруудын гарц нэмэгдэхээс гадна хүн амын хэрэглээ илүү үйлчилгээнд чиглэж байгаа нь эдгээр салбарын хөгжилд ихээхэн дэмжлэг үзүүлэх юм.

Эдгээр бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлснээр Монгол Улсын ДНБ 2015 онд 10 хувиар, 2016-2017 онд 6-8 хувиар өсөхөөр төсөөлж байна.

Инфляци

2013 оны жилийн эцсийн байдлаар хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн түвшин улсын хэмжээнд 12.5 хувь, Улаанбаатарын хэмжээнд 12.3 хувьтай гарсан байна.

Улаанбаатар хотын инфляцийн задаргаанаас харахад 2009 он хүртэл хүнсний инфляци давамгайлдаг байсан бол иргэдийн хэрэглээний бүтцэд өөрчлөлт орж махнаас бусад хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт харьцангуй буурч, харин хүнсний бус бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт давамгайлах хандлагатай болсон байна.

Инфляцийн түвшинг бууруулж, тогтворжуулах бодлого баримтлах үүднээс Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжих чиглэлээр газрын тосны үйлдвэр байгуулах, импортоор оруулж байгаа гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, барилгын материалын импортыг бууруулж, дотоодод үйлдвэрлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

2012 оны 10 сард Засгийн газар, Монголбанк хооронд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулан, энэ хүрээнд дунд хугацааны 4 дэд хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж байна. /Жич: Сүүлд 5 дахь дэд хөтөлбөр болох “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах” нэмэгдсэн./ Үүнд:

2. “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр
3. “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөр
4. “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр
5. “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр
6. “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөр

2013 онд эдгээр дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр хэрэглээний үнийн сагсны гол бүтээгдэхүүнүүд болох шатахуун, мах, гурилын үнэ харьцангуй тогтвортой байна. Тухайлбал, “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр махны үнийн өсөлт 2012 онд нийт инфляцийн 37.7 хувийг бүрдүүлж байсан бол 2013 онд 14.7 хувийг бүрдүүлсэн байна. Мөн гурилын үнийн өсөлт харьцангуй тогтвортой байна. “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 онд 192 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор олгосон бөгөөд улмаар шатахууны үнэ 2011-2012 онуудад огцом өсч байсан бол өнгөрсөн онд тогтвортой байсан.

Мөн 2013 оны 5 сараас эхлэн манай улсын газрын тосыг боловсруулан хийсэн Мон-93 шатахууныг БНХАУ-аас импортолж оруулж ирж байгаа нь үнэ тогтвортой байх бас нэг шалтгаан болж байна.

“Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Замын-Үүдийн автозамын тээвэрлэх хүчин чадлыг 2 дахин өсгөж, төмөр замын ачаа тээвэрт хатуу зурмагийн галт тэрэгний үйлчилгээг нэвтрүүлж, нэг хоногт багтаан Замын-Үүдээс Улаанбаатарт ачаа хүргэх тогтолцоо бий болсноор импортын бүтээгдэхүүний тээврийн зардал буурч, дотоодын зах зээл дээрх үнэ харьцангуй тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлж байна. “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын нийлүүлэлтийг дэмжих, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд 169.7 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 1213.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт. Гол түнш орнуудын инфляцийн түвшин

	I.13	II.13	III.13	IV.13	V.13	VI.13	VII.13	VIII.13	IX.13	X.13	XI.13	XII.13	XII.14*
БНХАУ	1.9	3.2	2.1	2.4	2.1	2.7	2.7	2.6	3.1	3.2	3.0	2.5	2.5
АНУ	1.6	2.0	1.5	1.1	1.4	1.7	2.0	1.5	1.2	1.0	1.2	1.5	1.9
ОХУ	7.1	7.3	7.0	7.2	7.4	6.9	6.4	6.5	6.1	6.3	6.5	6.5	6.0

Эх үүсвэр: БНХАУ-ын Үндэсний Статистикийн хороо, * - хүлээгдэж буй гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад Хятад улсын инфляцийн хүлээгдэж буй түвшин 2014 онд 2.5 буюу харьцангуй бага байхаар байгаа нь манай улсын инфляцид учруулах дарамт бага байхаар байна. Харин ОХУ-ын хувьд 2013 онд инфляцийн түвшин 6.5 хувь байсан бол 2014 онд 6.0 хувь болж буурахаар хүлээгдэж байна.


2014 онд нийлүүлэлтийн шинж чанартай инфляцийн түвшин буурах хандлагатай байгаа бөгөөд мөн гол түнш орнуудын инфляцийн түвшин бага байхаар хүлээгдэж байгаа зэргээс үүдэн манай улсын инфляцийн түвшин 2014 онд нэг оронтой тоонд байлгах зорилтыг тавьж байна.

Дунд хугацаанд инфляцийн түвшинг нам, тогтвортой байлгах үүднээс Засгийн газраас нилээдгүй төсөл, хөтөлбөрүүдийг Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө тусган ажиллаж байна. Өргөн хэрэглээний гол бүтээгдэхүүн болох мах, гурил, барилгын материал, мөн суурь бүтээгдэхүүн шатахуун, эрчим хүчний үнийг төрөөс шууд бус аргаар зохицуулахаар төлөвлөж байна.

“Чингис Бонд”-оор босгосон хөрөнгийг дэд бүтэц, үйлдвэрлэлийн томоохон бүтээн байгуулалтыг дэмжихээр төлөвлөөд байна. Тухайлбал, импортын бараа, бүтээгдэхүүнийг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих төсөл, барилгын материалыг дотоодод үйлдвэрлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр инфляцийн түвшин дунд хугацаанд харьцангуй тогтвортой байхаар хүлээгдэж байгаа бөгөөд 2015-2017 онд инфляцийн түвшин 7 орчимд хувьд хэлбэлзэхээр байна.

График. Инфляцийн түвшний төсөөлөл




Гадаад худалдаа

Монгол улсын гадаад худалдааны бараа эргэлт 2013 онд 10.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 4.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Экспортын хэмжээ 2.6 хувиар, импортын хэмжээ 5.7 хувиар тус тус бууран нийт гадаад худалдааны алдагдал 11.5 хувиар багасан 2.0 тэрбум ам.долларт хүрэв. Гадаад худалдаа алдагдалтай гарах болсон гол шалтгаан нь экспортын нүүрс, зэсийн үнэ буурч, экспортын хэмжээ багасантай холбоотой юм.

Манай орон 2013 онд нийт 135 оронтой гадаад худалдаа хийснээс БНХАУ, Канад болон Их Британи улсуудтай хийсэн худалдаа хамгийн их ашигтай байсан бол ОХУ, Герман болон БНСУ зэрэг оронтой хийсэн худалдаанд импорт зонхилж байв.

График. Гадаад худалдаа сая ам.доллар



Манай улсын гадаад худалдаа 2015 онд 13.6 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаагаас экспорт 6.9 тэрбум ам.доллар, импорт 6.7 тэрбум ам.доллар болж 2014 оны байдлаас 23 хувь болон 8 хувь тус тус өсөн, гадаад худалдаа 128 сая ам.долларын ашигтай байхаар байна.

Экспорт. Монгол улсын нийт экспорт 2013 онд 2012 оноос 2.6 хувиар бууран нийт экспортын хэмжээ 4.3 тэрбум ам.доллар болов. Энэхүү бууралтад нөлөөлсөн гол хүчин зүйл нь манай орны экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох чулуун нүүрсний үнэ 92 доллараас 61 болж 31 ам.доллараар, хэмжээ 2 сая тонноор буусантай шууд холбоотой. Харин бусад экспортын гол бүтээгдэхүүнүүд болох зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй алт, боловсруулаагүй газрын тос зэргийн хэмжээ нь өсөн нийт экспортын бууралтыг сааруулсан байна.

Нийт экспортын 89 хувь нь эрдэс бүтээгдэхүүн байсан бол үүнээс зэсийн баяжмал 22.2 хувь, чулуун нүүрс 26.1 хувь, төмрийн хүдэр 15.3 хувь, боловсруулаагүй газрын тос 12.1 хувь болон боловсруулаагүй алт 7.3 хувийг тус тус эзэлж байна. Чулуун нүүрс өмнөх жилүүдэд экспортын ихэнх хувь буюу 42 хувь байснаас 26 хувь болж буусан нь 2013 онд зэсийн экспортод эзлэх хувь ихэссэн болон нүүрсний үнэ, хэмжээ буурсантай холбоотой. Зэсийн баяжмалын нийт экспортод эзлэх хэмжээ 22.2 хувь болж өссөн нь Оюу-Толгойн үйл ажиллагааны эхлэлтэй шууд хамааралтай юм. Цаашдаа Оюу-Толгой компаний үйл ажиллагаа хэвийн үргэлжилбэл зэсийн баяжмалын нийт экспортод эзлэх хэмжээ улам ихсэх төлөвтэй байна. Төмрийн хүдрийн олборлолт буурсан хэдий ч экспорт 2013 онд өмнөх оноос 4.8 хувиар ихэсч, 6.7 сая тонн болсон байна.

Нүүрсний гол боомт болох Гашуунсухайт-Ганц модны боомтод энэ жилд 18 км боомтын төмөр замыг 2014 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр боомт хоорондын нүүрсний тээвэрлэлтийн өртөгийг 8 ам.доллараас 1 ам.доллар хүртэл бууруулах боломжтой болно. Тус төмөр замыг барьснаар манай экспортын нүүрсний өрсөлдөх чадвар дээшилж, экспортын хэмжээг нэмэгдэх боломжтой болно. Мөн нүүрсний экспортод нэг цонхны худалдааны бодлогыг гол нүүрс экспортлогч компаниуд барин үйл ажиллагаагаа явуулвал Монголын нүүрс Хятад цаашлаад дэлхийн зах зээл дээр өрсөлдөх боломжтой болох юм.

Гадаад худалдааны бараа эргэлт 2014 оны эцэст ойролцоогоор 11.9 тэрбум ам.доллар болох төлөвтэй байгаагаас экспорт 2013 оноос 31.3 хувиар өсч 5.6 тэрбум ам.доллар, импорт 1.5 хувиар буурч 6.3 тэрбум ам.доллар болох төлөвтэй байна. Энэ өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь Оюу Толгойн зэсийн баяжмалтай холбоотойгоор өссөн мөнгөн дүн нь ойролцоогоор 2 тэрбум долларт хүрэхээр байна. Мөн нүүрс, төмрийн хүдэр, алт зэргийн экспорт өсөх нь нийт экспортын хэмжээг нэмэгдүүлэхээр байна.

Дунд хугацаанд Экспортын өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь:

- Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр зам тавигдаж, Боомтын төмөр зам баригдсанаар манай улсын нүүрсний өртөг буурч, өрсөлдөх чадвар сайжирч БНХАУ-д экспортлох нүүрсний хэмжээ нэмэгдэх боломжтой болно.
- БНХАУ, Энэтхэг, Зүүн Азийн орнуудын хүн амын худалдан авах чадвар сүүлийн жилүүдэд хурдтай нэмэгдэж, улмаар тансаг хэрэглээний бүтээгдэхүүн болох ноолуур, нарийн ноосон хувцас, эдлэлийн борлуулалт нэмэгдэж байгаа нь энэ төрлийн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ ойрын жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.

Импорт. Монгол улсын нийт импорт 2013 онд 6.4 тэрбум ам.доллар болж өмнөх оныхоос 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Импортын бууралтад гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотойгоор уул уурхайн машин механизмын импорт багассан, мөн шатахууны импорт багассан нь голлон нөлөөлөв. Мөн Оюу-Толгой төслийн эхний үе шатны бүтээн байгуулалтын ажил дууссантай холбоотойгоор импорт буурсан байна. Манай орны импортын бүтцэд машин, механизм, техник, тоног төхөөрөмж 37.5 хувь, барилгын гол нэр төрлийн материал 13.4 хувь болон эрдэс бүтээгдэхүүн тэр дундаа түлш, шатахуун 21.2 хувийг тус тус эзлэв. Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн гол түүхий эд болох түлшний хэмжээ 5.5 хувиар өсч 756 мянган тонн болоод байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хэмжээ 14.6 хувиас 15.8 хувь болон ихсэхэд хүнсний бүтээгдэхүүний импорт 6.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Аж үйлдвэр, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн эсрэгээрээ 85.5 хувиас 84 хувь болж буурсан нь дээр дурдсанчлан машин, тоног төхөөрөмжийн импорт 42.3 хувиас 37.5 хувь болон буурсан нь нөлөөлжээ.

Барилгын материалын импортын гол бүтээгдэхүүнүүдийн хэмжээ 2013 онд өсөлттэй байв. Үүнээс цементийн хэмжээ 1.2 сая тонноос 1.5 сая тонн, хар төмөрлөг 220-аас 298 мянган тонн болов. Хэдийгээр дээр дурдсан бүтээгдэхүүний биет хэмжээ өссөн боловч дэлхий зах зээл дээр тэдгээрийн үнэ буурснаар нийт импортод төдийлөн нөлөөгүй юм. Чингис бонд, Хөгжлийн банкны санхүүжилт болон Засгийн газар-Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох" хөтөлбөр, "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийн хүрээнд барилга, угсралт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдсэнтэй холбоотойгоор барилгын материалын хэрэгцээ өсөөд байна. Цаашлаад Монгол улс 2015 оноос дотоодын цементийн үйлдвэр болон хар төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулснаар

барилгын материалынхаа тодорхой хэсгийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, эдгээр бүтээгдэхүүний импортын хэрэгцээг бууруулах боломжтой болно.

2014 оны эхний 2 сарын байдлаар нийт импортын 44 хувийг газрын тосны бүтээгдэхүүн, 15 хувийг өргөн хэрэглээ, 4 хувийг хүнсний бараа, үлдсэн хэсгийг бусад төрлийн бараа, бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Эхний 2 сарын байдлаар дизель түлшний хэмжээ 61.4 хувь, шатахууны хэмжээ 26.9 хувиар тус тус буурсан нь нийт импортын бууралтын хэмжээний 20 хувийг тайлбарлаж байна. Мөн цемент, хар төмөрлөг, машин тоног төхөөрөмж тэр дундаа суудлын болон ачааны автомашины импортын хэмжээ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Монгол улс цаашид барилгын материалын гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн болох цемент, арматурын төмрийн үйлдвэрүүдийг барьснаар нийт импортын өсөлтийн хурд саарах нөхцөл бүрдэх юм. Мөн Засгийн газраас авч хэрэгжүүлж буй экспортод чиглэсэн, импортын орлох үйлдвэрүүдийг Хөгжлийн банкны санхүүгийн эх үүсвэр болон бусад бодлогоор дэмжиж, хөгжүүлэхээр зорьж байна. Ингэснээр импортын зарим бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломж бүрдэнэ. Манай улсын нийт импорт 2015 онд 8 хувиар нэмэгдэж 6.8 тэрбум ам.доллар болон өсөх хандлагатай байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлөхөөр байна.

- Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, барилга угсралтын ажил нэмэгдэж байгаа нь тус салбарт шаардлагатай импортын бараа, материалын хэмжээг нэмэгдүүлэх төлөвтэй байна.
- Чингис бонд, Хөгжлийн банкны хөрөнгөөр хэрэгжих Экспортод чиглэсэн, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төслүүдийн хүрээнд олон тооны машин, тоног төхөөрөмжүүд болон үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд импортоор орж ирэхээр байна.
- Түлш, шатахууны хэмжээ нь аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон хүн амын хэрэглээг дагаад өсөхөөр байна.
- Эдийн засгийн хурдтай өсөлтийг дагаад хүн амын бодит худалдан авах чадвар, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт, улсын төсөв эрчимтэй нэмэгдэж байгаа импортыг тэр хэмжээгээр нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Дунд хугацаанд буюу 2016-2017 онд Монгол улсын гадаад худалдаа эрчимтэйгээр нэмэгдэх төлөвтэй байна. Экспорт, импортын хэмжээ эдийн засгийн өсөлтийг даган тогтвортойгоор нэмэгдэж нийт гадаад худалдаа 2017 онд 15.9 тэрбум ам.доллар хүрэх төлөвтэй байна.

График. Гадаад худалдаа сая ам.доллар



Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд болох зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр болон боловсруулаагүй газрын тосны олборлолт нь экспортын хэмжээг өсгөхөөр байна. Гадаад худалдаа 2015 онд ашигтай гарах төлөвтэй байгаа боловч 2016-2017 онуудад уул уурхайд хэрэглэгдэх газрын тосны хэмжээ болон Оюу-Толгойн далд уурхайн үйл ажиллагаанд ашигладаг тоног төхөөрөмж орж ирэх нь импортын хэмжээг өсгөх нөхцөлийг бий болгоно.

Төлбөрийн тэнцэл

2013 оны гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 1883.3 сая ам.долларын алдагдалтай гарч гадаад валютын албан нөөц уг дүнгээр өөрчлөгдлөө. Өмнөх оны мөн үед төлбөрийн тэнцэл 1705 сая ам.долларын ашигтай гарч байсан.

Төлбөрийн тэнцлийг дансаар авч үзвэл, урсгал данс 3155.6 сая ам.долларын алдагдалтай гарч 2012 оны мөн үеэс алдагдал нь 6.1 хувиар буурсан, хөрөнгө ба санхүүгийн данс 1471.6 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 70.1 хувиар буурсан байна.

Хүснэгт. Төлбөрийн тэнцэл /сая.ам доллар/

	2012	2013	Жилийн өөрчлөлт, %
Төлбөрийн тэнцэл	1705	-1883.3	-210
Урсгал данс	-3,362.2	-3,155.6	-6.1
Хөрөнгө ба санхүүгийн данс	4,929.5	1,471.6	-70.1

Эх үүсвэр: ЭЗХЯ


Манай улсын боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт 2013 онд өмнөх оноос 2.5 дахин нэмэгдсэн бол нийт экспортын ихэнхи хувийг эзэлдэг нүүрсний экспорт 41 хувиар буурсан нь манай улсын нийт экспорт 2013 онд 2.6 хувиар буурахад нөлөөлсөн байна.

Үйлчилгээний тэнцлийн алдагдал 2013 онд 19.4 хувиар өссөн нь үйлчилгээний тэнцлийн 70-80 орчим хувийг бүрдүүлдэг тээврийн үйлчилгээний алдагдал 3 хувиар нэмэгдэж, аяллын үйлчилгээний ашиг 80.6 хувиар буурсантай холбоотой.

2013 онд Оюу Толгой төслийн эхний шатны хөрөнгө оруулалт дууссан болоод хөрөнгө оруулалтын орчны тогтворгүй байдалтай холбоотойгоор Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 54 хувиар буурсан нь санхүүгийн дансны ашиг буурахад нөлөөлсөн байна. Ийнхүү хөрөнгө оруулалт буурсан нь валютын зах дээрх гадаад валютын нийлүүлэлтийг бууруулж, улмаар төлбөрийн тэнцэлд дарамт үүсгэн, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад нөлөөлсөн суурь хүчин зүйл болсон байна.

Мөн Засгийн газраас экспортыг дэмжиж, импортыг орлох бодлого баримтлахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр худалдааны тэнцэл дунд хугацаанд эерэг буюу ашигтай байхаар хүлээгдэж байна. Түүнчлэн 2013 онд манай улсын Засгийн газраас гадаад зах зээлд шинээр 290 сая ам. долларын Самурай бонд босгож уг бондын санхүүжилт 2014 оны 1 сард орж ирээд байна. Үүний үр дүнд манай улсад орж ирэх валютын урсгал нэмэгдсэнээр төлбөрийн тэнцлийн алдагдал 2014 онд буурахаар хүлээгдэж байна.

График. Нийт төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/



Эх үүсвэр: ЭЗХЯ

2017 онд Хөгжлийн банкны бонд (580 сая ам.доллар) болон 2018 онд Чингис бонд (500 сая ам.доллар) -ын үндсэн төлбөрийг төлөхөөр байгаа нь санхүүгийн дансны ашиг буурахад нөлөөлж байна.

Ажилгүйдэл

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлогыг үндэсний болон орон нутгийн түвшинд Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, Хөдөлмөрийн төв бирж, Хөдөлмөрийн институт, Хөдөлмөрийн хэлтсүүд хөдөлмөрийн салбарын үйлчилгээг ард иргэдэд хүргэж байна.

Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн ам 2013 оны урьдчилсан байдлаар 1.2 сая орчимд хүрч, ажиллах хүчний оролцооны түвшин 63.4 хувьтай байна. Хөдөлмөрийн хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2013 оны эцэст 42.7 мянгад хүрсэн байна. Хөдөлмөрийн хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 63.0 хувийг 16-34 насны залуучууд эзэлж байна. Энэ нь хөдөлмөрийн насны иргэдийн ур чадвар хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийг төдийлөн хангаж чадахгүй байгаатай холбоотой байна.

Мөн улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2013 оны урьдчилсан байдлаар 7.5 хувьтай байхаар байна.

ҮСХ-ноос эрхлэн гаргадаг Ажиллах хүчний түүвэр судалгаанд үндэслэн тооцоход 2014-2017 онд ажиллагсдын тоо жилд дунджаар 1.5 хувиар өсч, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо дунджаар 34.0 мянга орчим байхаар байна. 2017 онд ажиллах хүчний оролцооны түвшин 63.5 хувь, ажил эрхлэлтийн түвшин 94.1 хувьд хүрэхээр байна.

Дунд хугацаанд Монгол Улсын иргэн бүр ажилтай, өрх бүр орлоготой болох үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 150.0 мянган ажлын байрыг бий болгон, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцсэн мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэхэд анхаарч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг зээл болон зээлийн баталгааны сангуудаар дамжуулан дорвитой дэмжих бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Уг арга хэмжээнүүдийн үр дүнд ажилгүйдлийн түвшин 2014 онд 7.1 хувьд, 2017 онд 5.9 хувьд тус тус хүрэхээр хүлээгдэж байна.

2. ДУНД ХУГАЦААНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ

Монгол улсын 2015 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь макро эдийн засгийн болон төсвийн тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцийг хязгаарлахад чиглэсэн дараах төсвийн бодлогоор тодорхойлогдож байна. Үүнд:

1. Төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээг 2.0 хувиас хэтрүүлэхгүй байх;
2. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн татварын орчныг бүрдүүлэх, татварын орчныг тогтвортой байлгах замаар төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох;
3. Тэвчиж болох урсгал зардлыг хэмнэх замаар урсгал зардлын суурийг нэмэгдүүлэхгүй байх;
4. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшинг харгалзан индексжүүлж нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
5. Төсвийн байгууллагуудын урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, урсгал зардлыг нэмэгдүүлэх үр дагавар бүхий аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхдээ төсвийн хязгаарт багтаах;
6. Төсвийн хөрөнгөөр хэрэгжих төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үр ашигтай болгох;
7. УИХ, Засгийн газраас шинээр батлагдсан хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг төсвийн боломж, нөөцтэй уялдуулан оновчтой зохион байгуулах, шаардлагатай нөхцөлд төсвийн урсгал зардлын суурь хязгаарт багтаан үе шаттайгаар эхлүүлэх.
8. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн төсөл арга хэмжээг барилгын тухай болон төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн төсөлд тусгах, төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулах чиглэл баримтлана.

3. МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 92.1 хувийн, нийт зарлага 90.8 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 297.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.7 хувийн алдагдалтай гарсан байна.

3.1 Төсвийн орлогын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,880.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөний биелэлт 92.1 хувь буюу 503.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин 2013 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 2012 оны мөн үетэй харьцуулахад 1,017.5 тэрбум төгрөгөөр буюу 20.9 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 89.1 хувийн биелэлттэй буюу 621.2 тэрбум төгрөгөөр буурсан нь өнгөрсөн онд нэгдсэн төсвийн орлого буурахад гол нөлөөг үзүүлсэн бол татварын бус орлого 118.6 тэрбум төгрөгөөр давж, 116.9 хувийн биелэлттэй гарлаа.

Орлогын албан татвар 194.5 тэрбум төгрөг, дотоодын бараа үйлчилгээний татвар 337.2 тэрбум төгрөг, гадаад худалдааны орлого 135.2 тэрбум төгрөгөөр тус тус

төлөвлөсөн хэмжээнээс дутуу төвлөрсөн нь нийт татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна.

Харин хүү торгуулийн орлого 69.7 тэрбум төгрөг, газрын тосны орлого 25.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь татварын бус орлогын төлөвлөгөө давж биелэхэд гол нөлөөг үзүүлжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 87.6 хувь, Орон нутгийн төсвийн орлогын биелэлт 100.4 хувь, Хүний хөгжил сангийн орлогын биелэлт 98.8 хувь, Нийгмийн даатгалын сангийн орлого 102.5 хувь байлаа. Дээрх мэдээллээс харахад улсын төсвөөс бусад төсвийн орлогын гүйцэтгэл батлагдсан хэмжээнд төвлөрсөн байна.

3.2 Төсвийн зарлагын гүйцэтгэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт зарлага 6,800.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6,178.0 тэрбум төгрөгийн буюу 90.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Үүнээс урсгал зардал 94.3 хувийн гүйцэтгэлтэй буюу бараа, үйлчилгээний зардал 94.3 хувийн, зээлийн үйлчилгээний төлбөр 86.2 хувийн, татаас ба шилжүүлэг 96.8 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.


Өнгөрсөн 2013 онд Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа зарим хөтөлбөр, арга хэмжээг оновчтой болгох, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнг сайжруулж хэмнэлттэй зохион байгуулах чиглэлээр дараах арга хэмжээг бүх төсвийн ерөнхийлөн захирагч авч хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- Төсийн байгууллагуудын урсгал зардал, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, орон тоо, урсгал зардлыг нэмэгдүүлэх үр дагавар бүхий аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхдээ ажлын ачааллыг нягтруулах, бүтэц-чиг үүргийг оновчтой тогтоох замаар төсвийн хязгаарт багтаах;
- Төсвөөс олгож байгаа татаас, урамшууллын бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлэх замаар эдийн засгийн үр ашигтай, үндэсний аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, цаашид бие даан хөгжих чадавхийг бүрдүүлэхэд илүүтэй чиглүүлэх, хяналт тавих механизмыг бий болгох замаар төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Төсвөөс нэмэлт санхүүжилт шаардах хөтөлбөр, арга хэмжээг шинээр эхлүүлэхгүй байх төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилттэй уялдуулах, хүрэх үр дүн болон тэргүүлэх ач холбогдлыг харгалзан тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хязгаарт багтаан дахин хуваарилах замаар шийдвэрлэх;

Орон нутгийн төсвийн зарлага 89.6 хувь буюу 1,765.1 тэрбум төгрөгийн, Нийгмийн даатгалын сан 98.7 хувь буюу 1,054.2 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бол Хүний хөгжил сангийн зарлага 277.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн зардал 98.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 229.0 тэрбум төгрөг, өмнөх онуудад иргэдэд олгосон 21000 төгрөгийг нөхөн олгоход 27.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Урсгал зардлын өсөлтөд нөлөөлж буй гол хүчин зүйлс: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардал 2003 онд 615.8 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 6,178.0 тэрбум төгрөг болж, урсгал зардал 470.0 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 4,559.3 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн хугацаанд ойролцоогоор 10 дахин буюу 4,089.3 тэрбум төгрөгөөр тэлсэн байна.

График. Урсгал зардлын өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс



Нийт урсгал зардлын өсөлтийн 50.2 хувь нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтөөс, 10.9 хувь нь нийгмийн халамжийн зардлын өсөлт, 11.7 хувь нь төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламж, мөн хууль тогтоомж батлагдсанаар үүссэн бүтэц, орон тооны өөрчлөлтөөс, 8.6 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 8.4 хувь нь хэрэглээний үнийн өсөлтөөс хамаарсан бараа, үйлчилгээний зардлын өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхэд цалин, хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх шийдвэрүүд хамгийн их нөлөөлсөн байна. Жишээлбэл, 2003 онтой харьцуулахад нийт зарлагад цалингийн сангийн зардлын өсөлт 31.6 хувийг эзэлж байгаа бол, үүнээс 24.4 хувь нь цалин хөлсийг өнгөрсөн хугацаанд дунджаар 9.4 дахин нэмэгдүүлж шийдвэрлэсэнээс, 7.2 хувь нь орон тоо өссөнөөс шалтгаалсан байна.

Орон тооны өсөлтөд хууль тогтоомж шинээр батлагдах, төрөөс баримталж буй аливаа бодлогод томоохон өөрчлөлт гарсны улмаас хийгдэж буй бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, мөн нийгмийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламжийг шинээр ашиглалтад оруулах зэрэг хүчин зүйлс ихээхэн нөлөөлж байна. Жишээлбэл, сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтаар баригдаж буй сургууль, цэцэрлэг болон эмнэлэг шинээр ашиглалтад орох, мөн ерөнхий боловсролын сургуулийг 10 жилээс 12 жилийн сургалттай болгох зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

Хүснэгт. Урсгал зардлын бүтэц, эдийн засгийн томсгосон ангиллаар

Төсвийн зарлагын ангилал	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
1 Төсвийн нийт зарлага	1,238.1	1,747.3	2,466.8	2,336.6	3,080.7	4,997.0	6,017.8	6,178.0	7,294.2
2 Урсгал зарлага	1,043.7	1,367.7	1,761.2	1,788.2	2,256.7	3,236.4	4,428.1	4,559.3	5,326.7
2.1 Цалин хөлс ба НДШ	23%	26%	34%	35%	31%	27%	30%	34%	32%
2.2 Бараа, үйлчилгээний бусад	48%	28%	29%	22%	23%	22%	19%	22%	20%
2.3 Татаас, шилжүүлэг	26%	49%	39%	44%	46%	54%	51%	42%	41%
2.4 Зээлийн хүү	8%	6%	5%	0%	10%	15%	1%	6%	9%

Нийт урсгал зардын бүтцийг авч үзвэл цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 23 хувиас 30-35 хувь хүртэл нэмэгдэх хандлагатай байгаа нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийг 2007 оноос эхлэн шат дараатайгаар өндөр хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Харин бараа, үйлчилгээний бусад зардлын эзлэх хувь энэ хугацаанд 48 хувиас 20 хувь хүртэл буурах хандлагатай байна. Урсгал зардалд эзлэх зээлийн үйлчилгээний зардлын хэмжээ дунджаар 8-9 хувьтай байгаа бол татаас болон шилжүүлгийн зардал 2007 оноос эрс нэмэгдэж 45-50 хувийг эзэлж байсан бол 2013 оноос буурах хандлагатай байна. Энэ нь Хүний хөгжил сангаас 2010-2012 онуудад иргэдэд бэлэн мөнгө олгож байсан нь нөлөөлсөн байна.

2013 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаар: Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар нийт 1,124.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 787.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, төлөвлөгөөний биелэлт 70.1 хувьтай гарсан байна.

Төсвийн тухай хуулийн 43.4 дэхь заалтын дагуу 2012 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2013 оны 1-3 дугаар саруудад нийт 182.8 тэрбум төгрөг санхүүжүүлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад өнгөрсөн 2013 онд нийт 970.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өнгөрсөн хугацаанд улсын төсвөөс хийгдсэн хамгийн их хөрөнгө оруулалттай жил болсон байна.

4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2014 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын 2014 оны батлагдсан төсвөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого **6,883.9 тэрбум төгрөг** буюу **ДНБ-ий 33.6 хувь**, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага **7,293.8 тэрбум төгрөг** буюу **ДНБ-ий 35.6 хувь**, нэгдсэн төсвийн нийт алдагдал **409.9 тэрбум төгрөг** буюу **ДНБ-ий 2.0 хувь**тай байхаар хуульчлагдсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг ДНБ-ий 33.6 хувь буюу 6,883.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2013 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээс 1,003.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 90.5 хувь буюу 6,227.2 тэрбум төгрөг нь татварын орлого, үлдэх 9.5 хувь буюу 656.2 тэрбум төгрөг нь татварын бус орлого байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2014 оны 1 дүгээр улирлын байдлаар 1,149.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 20.8 хувиар буюу 301.7 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 4.1% буюу 46.1 тэрбум төгрөгөөр давсан байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлс: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 2013 оны урьдчилсан гүйцэтгэл, 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс буурахад дараахь хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

I. Эрдэс бүтээгдэхүүний үнэ, экспортын бууралт

Монгол Улс 2013 онд нийт экспортын бүтээгдэхүүний 87 хувийг БНХАУ-д гаргасан байгаа нь нэг улсын эдийн засаг, үйлдвэрлэл, түүнээс хамаарсан бүтээгдэхүүний эрэлтээс дотоодын эдийн засаг шууд хамаарах эрсдэлийг дагуулж байна.

Манай улс 2012 онд БНХАУ-ын коксжих нүүрсний нийт импортын 58 хувийг хангадаг байсан бол 2013 онд 16 хувь болж буурчээ. Нүүрс тээвэрлэх зардал өндөртэй манай улсын хувьд коксжих нүүрсний үнийн бууралт нь аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг бууруулж байна. Ийнхүү нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн бууралт нь татварын орлого буурахад нөлөө үзүүлж болзошгүй байна.

Хүснэгт: Эрдэс бүтээгдэхүүний 2014 оны экспортын тоо хэмжээ, үнэ

Үзүүлэлт	Биет хэмжээ			Үнэ		
	Төлөв	Хандлага	Зөрүү	Төлөв	Хандлага	Зөрүү
Нүүрс /сая.тн/	31.4	24.0	-7.4	115.9; 81.6	81.1; 57.3	-34.8; 24.3
Зэсийн баяжмал /мян.тн/	1,225.1	1,116.9	-108.2	6,242.0	6,242.0	0
Төмрийн хүдэр /мян.тн/	7,804.0	7,712.0	-92.0	106.0	106.0	0
Цайрын баяжмал /мян.тн/	88.0	88.0	0	1,987.0	1,987.0	0
Жонш /мян.тн/	315.1	315.1	0	315.1	315.1	0
Алт /тн/	31.6	26.9	-4.7	1,269.6	1,269.6	0

II. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт

Гадаадын хөрөнгө оруулалт 2013 онд өмнөх оноос 55 хувиар буурсан байна. Оюу толгой төслийн ил уурхайн бүтээн байгуулалтын ажил дууссан бөгөөд төслийн 2 дахь үе шатны бүтээн байгуулалтын санхүүжилтийн асуудал хүлээгдэж байна. Хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал буурах нь төсвийн орлогод сөргөөр нөлөөлнө.


III. Эдийн засгийн өсөлт

Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засаг, үйлдвэрлэлийн өсөлт саарсны улмаас эрдэс бүтээгдэхүүний экспорт багасч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш их хэмжээгээр буурч, инфляци өсч байгаагийн улмаас аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж, ашигт ажиллагааны түвшинг их хэмжээгээр бууруулж, улмаар татварын орлогын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

IV. Импортын бууралт

Энэ оны эхний улирлын байдлаар нийт импорт 996.0 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 209.1 сая ам.доллар буюу 17.3 хувиар буурсан байгаа нь импортоос хамааралтай татварын орлогын төлөвлөгөө буурах үндсэн шалтгаан болж байна.

График. Импортын бүтэц



5. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2015-2017 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

5.1 ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг баримтлан Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хүснэгт. Монгол улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	2015 ТХМ	ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ	
			2016	2017
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ, хувь	10.2	7.0	5.9
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,201.1	7,322.2	7,793.0
	- ДНБ-д эзлэх хувь	29.4	26.5	25.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,690.9	7,874.9	8,400.7
	- ДНБ-д эзлэх хувь	31.4	28.5	27.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ	397.0	184.0	525.8
	- ДНБ-д эзлэх хувь	1.6%	0.7%	1.7%
	Зарлагын өсөлтийн хувь	5.4%	2.4%	6.7%
	Эрдэс баялгийн бус ДНБ өсөлтийн хувь	14.8%	13.5%	11.5%
	Өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж	23.4%	23.4%	22.7%
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-489.8	-552.7	-607.7
	- ДНБ-д эзлэх хувь	-2.0%	-2.0%	-2.0%
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,967.3	2,026.3	2,127.7
	- ДНБ-д эзлэх хувь	8.0%	7.3%	7.0%
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	17,143.8	19,345.6	21,270.4
	- ДНБ-д эзлэх хувь	70.0%	70.0%	70.0%
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	272.8	285.8	298.8
	- ДНБ-д эзлэх хувь	1.1%	1.0%	1.0%

5.2 ТӨСВИЙН ОРЛОГО

Дэлхийн эдийн засгийн 2015 оны нөхцөл байдал ба ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн хандлага

Дэлхийн эдийн засаг, тэр дундаа европ болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд 2012 оноос эхлэн удааширч байгаа бөгөөд энэ нь 2015, 2016 онд үргэлжлэх төлөвтэй байна. Португал, Грек, Испани, Итали зэрэг улсуудын өрийн


хямрал болон ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь дэлхийн нийт бараа, бүтээгдэхүүний гуравны нэгийг хэрэглэдэг Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг сааруулж, улмаар хэрэглээг бууруулж байна.

АНУ-ын өрийн хэмжээ ДНБ-ийн 70 орчим хувьд хүрч, нөгөөтэйгүүр эрүүл мэндийн салбарын төсвийн зардлыг ихээхэн нэмэгдүүлж байгаа нь тус улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж, хэрэглээг мөн бууруулах төлөвтэй байна.

Ийнхүү дэлхийн томоохон худалдан авагч улс орнуудын хэрэглээ хумигдсан тул БНХАУ-ын үйлдвэрлэл буурах хандлагатай байна. Түүнчлэн, тус улс байгаль орчинд халтай технологи, үйлдвэрлэлийг бууруулах ногоон хөгжлийн бодлого баримталж эхлээд байна. Тухайлбал, технологийн хувьд хоцрогдсон гангийн үйлдвэрүүдийн тоог цөөлж, хүчин чадлыг 27 сая тонноор бууруулах, мөн гангийн үйлдвэрт ашиглагддаг 50 мянган ширхэг нүүрсний зуухыг хэрэглээнээс гаргахаар шийдвэрлэжээ². БНХАУ-ын үйлдвэрлэлийн хэмжээ, бусад улс орнуудын хэрэглээ ийнхүү буурч байгаа нь манай улсын эрдэс бүтээгдэхүүний экспорт, бүтээгдэхүүний үнэ буурах нөхцлийг бүрдүүлж байна.

БНХАУ нь дэлхийн ашигт малтмалын бүтээгдэхүүний 40 орчим хувийг дангаараа хэрэглэж байна. Өнгөрсөн 2013 оны байдлаар дэлхийн зэсийн хэрэглээний 47 хувь, ган төмрийн хэрэглээний 45.9 хувь, коксжих нүүрсний худалдааны 30 орчим хувийг тус улс дангаараа бүрдүүлжээ. Үүнээс үзэхэд БНХАУ-ын эдийн засаг нь дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэд хүчтэй нөлөө үзүүлж байна.

График. Дэлхийн гангийн хэрэглээ болон БНХАУ-ын гангийн хэрэглээ



Эх сурвалж: Австралийн Эрдэс баялаг, эрчим хүчний эдийн засгийн хороо (BREE)

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан манай улсын экспортын гол нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний 2014-2016 оны үнийн төсөөллийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт. Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014*	2015*	2016*
Зэсийн үнэ (\$/тн)	7,538.4	8,823.5	7,958.9	7,331.5	6,836.0	6,533.3	6,500.0
Алтны үнэ (\$/унци)	1,224.5	1,571.5	1,669.0	1,411.2	1,269.6	1,303.3	1,303.8
Коксжих нүүрсний үнэ (\$/тн)	128.5	180.7	148.4	96.2	81.8	77.4	73.9

Эх сурвалж: Блумберг мэдээллийн агентлаг

² <http://time.com/12594/china-pollution-li-keqiang-declares-war/>

Дэлхийн зах зээл дээрх гангийн хэрэглээ болон БНХАУ-ын гангийн хэрэглээний өсөлтийн хурд ирэх жилүүдэд саарахаар байна. Судалгаанаас харахад БНХАУ-ын гангийн хэрэглээний өсөлт 2015-2017 онд өмнөх жилүүдээс буурч 1.9-2.9 хувь байхаар төсөөлсөн байна. Харин зэсийн хэрэглээ харьцангуй тогтвортой өсч 3.5-3.6 хувьд байх хандлагатай байна.

Хүснэгт. Дэлхийн болон БНХАУ-ын зэс, гангийн хэрэглээ /сая тонн/

Он	Дэлхийн гангийн хэрэглээ	БНХАУ-ын гангийн хэрэглээ	Дэлхийн зэсийн хэрэглээ	Дэлхийн гангийн хэрэглээний өсөлт	БНХАУ-ын гангийн хэрэглээний өсөлт	Дэлхийн зэсийн хэрэглээний өсөлт
2012	1,527.0	669.0	20.1	2.8%	2.9%	2.5%
2013	1,586.0	729.0	21.0	3.9%	9.0%	4.8%
2014*	1,629.0	751.0	21.8	2.7%	3.0%	3.9%
2015*	1,663.0	773.0	22.6	2.1%	2.9%	3.6%
2016*	1,701.0	793.0	23.4	2.3%	2.6%	3.5%
2017*	1,734.0	808.0	24.3	1.9%	1.9%	3.5%

Эх сурвалж: Австралийн Эрдэс баялаг, эрчим хүчний эдийн засгийн хороо (BREE), Блүмберг

Ийнхүү дэлхийн болон БНХАУ-ын гангийн хэрэглээний өсөлт саарахаар байгаа нь тус үйлдвэрлэлийн гол түүхий эд болох коксжих нүүрсний эрэлт, үнийг бууруулах эрсдэлтэй байна. Нөгөө талаас, БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хэмжээний өсөлт буурах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээ

Он	БНХАУ-ын коксжих нүүрсний импорт	Австрали Улсын коксжих нүүрсний экспорт	Дэлхийн коксжих нүүрсний худалдаа	БНХАУ-ын коксжих нүүрсний импортын өсөлт
2010	48.0	159.0	273.0	
2011	38.0	133.0	253.0	-20.8%
2012	52.0	144.0	272.0	36.8%
2013	93.0	170.0	314.0	78.8%
2014*	101.0	174.0	321.0	8.6%
2015*	104.0	182.0	328.0	3.0%
2016*	108.0	184.0	335.0	3.8%
2017*	107.0	191.0	338.0	-0.9%

Эх сурвалж: Австралийн Эрдэс баялаг, эрчим хүчний эдийн засгийн хороо (BREE), Блүмберг

Экспорт болон төсвийн орлогод уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа бөгөөд олон улсын зах зээл дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл манай улсын эдийн засаг, төсөвт хүчтэй нөлөө үзүүлсэн хэвээр байна.

Хүснэгт. Монгол Улсын эдийн засгийн өсөлт

Үзүүлэлт	2011	2012	2013	2014*	2015**	2016**	2017**
ДНБ-ий бодит өсөлтийн хувь	17.5%	12.4%	11.7%	11.2%	10.2%	7.0%	5.9%
Өөрчлөлт		-5.1%	-0.7%	-0.5%	-1.0%	-3.2%	-1.1%

Нэгдсэн төсвийн 2015-2017 оны орлогын төсөөлөл


Дунд хугацааны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахдаа өнөөгийн мөрдөж буй хууль эрх зүйн орчин, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрүүдийн хүрээнд эдийн засгийн өсөлт, гадаад, дотоод орчны нөхцөл байдалд үндэслэн тооцох зарчмыг баримталлаа.

Хүснэгт. Төсвийн орлого, түүний ДНБ-д эзлэх хувь

Төрөл	2015*	2016**	2017**
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7,201.0	7,322.2	7,792.9
Тэнцвэржүүлсэн орлого ДНБ-д эзлэх хувь	29.4%	26.5%	25.6%

ДНБ-д эзлэх Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хувь ирэх жилүүдэд тогтвортой буурч, эдийн засаг дахь татварын ачаалал багасахыг илтгэж байна.


График. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь



Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3. "а"-д заасны дагуу 2015-2017 онуудад тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж буй гол нэр төрлийн эрдэс баялагт зэс болон нүүрс багтаж байгаа тул эдгээр бүтээгдэхүүний үнийн төсөөллийг хуульд заасны дагуу тэнцвэржүүлэх зарчмаар тооцсон болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2015-2017 онд баримтлах зэс, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тооцсон бөгөөд ОУВС-аас мэдээлсэн сүүлийн 12 жилийн зэс, нүүрсний үнийн мэдээллийг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна:

График. ОУВС-аас нийтэлсэн зэс, нүүрсний үнэ



Дэлхийн зах зээл дээрх санхүү, эдийн засгийн мэдээллийг нийтэд түгээдэг “Bloomberg” мэдээллийн эх сурвалжид заасан “Capital Economics Ltd” компний зэс, нүүрсний 2014-2017 оны үнийн төсөөллийг үндэслэн тэнцвэржүүлсэн үнийн төсөөллийг тооцлоо.

Хүснэгт. Зэсийн тэнцвэржүүлсэн үнийн тооцоо

Байгууллагын нэр	Огноо	2014 он	2015 он	2016 он	2017 он	2014-2017 Дундаж	ОУВС-ын дундаж үнэ	Тэнцвэржүүлсэн үнийн хувилбар
Intesa Sanpaolo SpA	3/26/14	7090	7075	7250		7,138.3		6,382.65
Capital Economics Ltd	3/04/14	6800	6300	6500		6,533.3	5,627.0	6,080.15
Westpac Banking Corp	2/28/14	6453	7002	7920	7006	7,095.2		6,361.11

Хүснэгт. Нүүрсний тэнцвэржүүлсэн үнийн тооцоо

Байгууллагын нэр	Огноо	2014 он	2015 он	2016 он	2017 он	Дундаж	Тэнцвэржүүлсэн үнийн хувилбар		
							ОУВС-ын дундаж үнэ	Боловсруулагүй	Баяжуулсан
Capital Economics Ltd	03/04/14	74.0	64.0	60.0		66.0		60.88	71.71
Societe Generale SA	11/26/13	83.1	87.4	92.3	97.1	90.0	77.4	71.06	83.7

Зэс, нүүрснээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний дунд хугацааны үнийн төсөөллийг ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл боловсруулдаг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын боловсруулсан үнийн төсөөлөлд үндэслэн тооцлоо.

Хүснэгт. Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ


Үзүүлэлт	Биет хэмжээ			Үнэ		
	2014 Төсөөлөл	2015 Төсөөлөл	Зөрүү	2014 Төсөөлөл	2015 Төсөөлөл	Зөрүү
Нүүрс /сая.тн/	24.0	31.4	7.4	81.1; 57.3	71.7, 60.9	(8.3); 8.9
Зэсийн баяжмал /мян.тн/	1,116.9	1,282.4	165.5	6,242.0	6,080.2	(161.8)
Төмрийн хүдэр /мян.тн/	7,712.0	9,000.0	1,288.0	106.0	106.7	
Цайрын баяжмал /мян.тн/	88.0	100.0	12.0	1,987.0	1,796.0	
Жонш /мян.тн/	315.1	330.0	14.9	315.1	270.0	
Алт /тн/	26.9	33.7	6.7	1,269.6	1,303.3	

Гадаад тусламжаар 2015 онд 159.3 тэрбум төгрөг, 2016 онд 54.6 тэрбум төгрөг, 2017 онд 18.3 тэрбум төгрөг тус тус төсвийн орлогод оруулан тооцсон болно.

5.3 ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2015 онд 7,690.9 тэрбум төгрөгт буюу ДНБ-ий 31.4 хувьд хүрэхээр төсөөллөө. Үүнээс төсвийн урсгал зарлага нь 5,796.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 23.7 хувь, хөрөнгийн зардал 1,967.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 8.0 хувь байхаар тооцлоо.

График. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, тэрбум төгрөг



Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2016 онд 7,874.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 28.5 хувь, 2017 онд 8,400.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.6 хувьтай тус тус тэнцэхээр байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан төсвийн нийт зарлагыг ДНБ-ий 40.0 хувиас бага байлгах зорилтыг хангах, төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулах зорилт тавьж байна.

Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016 – 2017 оны төсвийн төсөөлөлд дараах зарчмыг баримталж байна. Үүнд:

- Төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээг 2.0 хувиас хэтрүүлэхгүй байх;
- Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн татварын орчныг тогтвортой байлгах замаар төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох;
- Тэвчиж болох урсгал зардлыг хэмнэх замаар урсгал зардлын суурийг нэмэгдүүлэхгүй байх;
- Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшинг харгалзан индексжүүлж нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Төсвийн байгууллагуудын урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, урсгал зардлыг нэмэгдүүлэх үр дагавар бүхий аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхдээ төсвийн хязгаарт багтаах;
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжих төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үр ашигтай болгох;
- УИХ, Засгийн газраас шинээр батлагдсан хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг төсвийн боломж, нөөцтэй уялдуулан оновчтой зохион байгуулах, шаардлагатай нөхцөлд төсвийн урсгал зардлын суурь хязгаарт багтаан үе шаттайгаар эхлүүлэх.

*Хүснэгт. Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал, өсөлтийн хувь 2010-2015**

УРСГАЛ ЗАРДАЛ	2010 Гүйц	2011 Гүйц	2012 гүйц	2013 Урьд гүйц.	2014 Бат	2015 ТХМ
1. Бараа, үйлчилгээний зардал	1,166.7	1,528.1	2,052.4	2,393.6	2,650.9	3,151.3
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	42.3	37.3	126.0	270.5	462.5	432.5
3. Татаас ба урсгал шилжүүлэг	1,047.6	1,669.0	2,249.7	1,895.2	2,212.8	2,212.8
НИЙТ ДҮН	2,256.7	3,234.4	4,428.1	4,559.3	5,326.3	5,796.6

Төсвийн хүрээний мэдэгдэлд тооцсон урсгал зарлагын ДНБ-нд эзлэх хувь хэмжээ 2010-2013 онд дунджаар 30 орчим хувьтай байсан бол 2014 онд 26.0 хувь, 2015 онд 23.7 хувь, 2016-2017 онд дунджаар 21.0 орчим хувьтай байхаар байна.

2015 оны төсвийн урсгал зардлын түвшинд нөлөөлж буй гол хүчин зүйл

Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016 – 2017 оны төсвийн төсөөлөлд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний зардлыг тусгалаа. Засгийн газраас 2014 оны төсвийн жилд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2015 онд цалингийн суурь зардал 2014 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 178.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ, Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн дагуу 2015 онд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцийн түвшинг харгалзан индексжүүлэн нэмэгдүүлэхэд 122.0 тэрбум төгрөг нэмж шаардагдаж байна. Ийнхүү 2015 оны төсвийн жилд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд нийт 300.0 орчим тэрбум төгрөгийг нэмж тусгаад байна.

Хөрөнгө оруулалтын төсөөлөл

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн төсөл арга хэмжээг барилгын тухай болон төвийн тухай хуульд заасны дагуу төсвийн төсөлд тусгах, төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулах чиглэл баримтлана. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2015 онд 1,014.0 тэрбум төгрөг болохоор байна. Үүнээс гадна гадаад тусламжийн орлогоор нийт 59.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.

5.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газраар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барихыг дэмжээд буй Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тодорхойлолт, түүний хязгаарт өөрчлөлт оруулахаар тусгаад байна.

Уг хуулийн төсөл батлагдсанаар төсвийн тусгай шаардлага дахь улсын өр гэсэн ойлголтыг “Засгийн газрын өр” болгон өөрчилж, Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 70 хувиас, Засгийн газрын өрийн баталгааны нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 20 хувиас тус тус хэтрэхгүй байхаар хязгаарлалт тавигдах юм.

“Өрийн удирдлагын тухай” хууль батлагдсанаар Засгийн газрын өрийн хэмжээ дараах тооцоололтой байна.

Хүснэгт. Засгийн газрын өрийн тооцоолол

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2014	2015	2016	2017
Засгийн газрын өр (1+2+3+4+5)					
1)	Засгийн газрын гадаад зээлийн өрийн үлдэгдэл	3,635.8	4,286.3	4,763.3	4,788.0
	1.1 Гадаад зээлийн ашиглалт	297.3	786.8	617.8	179.5
	1.2 Гадаад зээлийн өрийн үйлчилгээний төлбөр	315.8	174.1	181.7	197.1
	1.2.1 Гадаад зээлийн үндсэн төлбөр	274.7	136.2	140.7	154.8
	1.2.2 Гадаад зээлийн хүүгийн төлбөр	41.1	37.8	41.0	42.2
2)	Засгийн газрын дотоод үнэт цаасны өрийн үлдэгдэл	2,845.2	3,213.9	3,271.7	3,897.1
	2.1 Дотоодод шинээр гаргах үнэт цаас	1,540.4	1,100.0	1,500.0	1,650.0
	2.2 Дотоод үнэт цаасны үйлчилгээний төлбөр	737.8	1,028.6	1,825.3	1,403.1
	2.2.1 Дотоод үнэт цаасны үндсэн төлбөр	544.8	731.4	1,442.2	1,024.6
	2.2.2 Дотоод үнэт цаасны хүүгийн төлбөр	193.0	297.2	383.2	378.5
3)	Хөгжлийн банкнаас авсан дотоод өрийн үлдэгдэл	831.5	945.1	1,048.7	710.9
4)		2,536.9	2,428.7	2,371.5	2,310.0

Засгийн газрын гадаад үнэт цаасны өрийн үлдэгдэл					
3.1	Олон улсын зах зээлд шинээр гаргах үнэт цаас	0.0	0.0	0.0	0.0
3.2	Гадаад үнэт цаасны үйлчилгээний төлбөр	121.5	112.7	112.1	111.6
3.2.1	Гадаад үнэт цаасны үндсэн төлбөр	0.0	0.0	0.0	0.0
3.2.2	Гадаад үнэт цаасны хүүгийн төлбөр	121.5	112.7	112.1	111.6
5)	Татварын урьдчилгаа төлбөр	396.6	287.8	0.0	0.0
Засгийн газрын өр (1+2+3+4+5)		10,245.9	11,161.7	11,455.2	11,706.0
Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийг ДНБ-д харьцуулсан харьцаа					
/Засгийн газрын өрийн дээд хязгаар/		70.0%	70.0%	70.0%	70.0%
Засгийн газрын өр / ДНБ		48.3%	45.6%	41.4%	38.5%

“Засгийн газрын өр”-ийг нэгтгэн бүртгэхдээ дараах 5-н катерогид хувааж авч үзсэн. Үүнд:

1. Засгийн газрын гадаад зээл

Засгийн газрын гадаад зээлийн өрийн үлдэгдэл 2013 онд 3,613.2 тэрбум төгрөг, 2014 онд 3,635.8 тэрбум төгрөг, 2015 онд 4,286.3 тэрбум төгрөг, 2016 онд 4,763.3 тэрбум төгрөг, 2017 онд 4,788.0 тэрбум төгрөг тус тус байхаар байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар, түнш орон, олон улсын санхүүгийн байгууллагаас өмнө байгуулагдсан зээлийн гэрээнүүдийн хүрээнд 2013 онд 321.1 тэрбум төгрөг авч ашигласан гүйцэтгэлтэй байгаа ба 2014 оны Төсвийн тухай хуульд 297.3 тэрбум төгрөгийг авч ашиглахаар батлагдсан. Түүнчлэн ирэх онуудад өмнө нь авсан зээл болон шинээр авах зээлийн хүрээнд 2015 онд нийт 786.8 тэрбум төгрөг, 2016 онд 617.8 тэрбум төгрөг, 2017 онд 179.5 тэрбум төгрөгийг тус тус авч ашиглахаар байна.
- Засгийн газрын гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт дээр дурдсан ашиглалтуудыг нэмсэн дүнгээр 2014 онд 315.8 тэрбум төгрөг, 2015 онд 174.1 тэрбум төгрөг, 2016 онд 181.7 тэрбум төгрөг, 2017 онд 197.1 тэрбум төгрөгийг төлөх төлөвлөгөөт хуваарьтай байна.

2. Засгийн газрын дотоод өр

Монголбанкнаас авч ашигласан дотоод зээлийн үлдэгдэл 2013 оны жилийн эцсийн байдлаар байхгүй байгаа бөгөөд Засгийн газрын дотоодын зах зээлд гаргасан үнэт цаасны өрийн үлдэгдэл 2013 онд 1,849.6 тэрбум төгрөг, 2014 онд 2,845.2 тэрбум төгрөг, 2015 онд 3,213.9 тэрбум төгрөг, 2016 онд 3,271.1 тэрбум төгрөг, 2017 онд 3,897.1 тэрбум төгрөг байхаар байна. Энэхүү тооцоололд 2016-2017 онд шинээр гаргах үнэт цаасны хэмжээг сүүлийн 3-н жилийн ДНБ-д эзлэх улсын төсвийн алдагдалтай тэнцүү байхаар авч үзсэн.

3. Хөгжлийн банкнаас авсан дотоод өр

Монгол Улсын Хөгжлийн банкны 2012 онд гаргасан 580.0 сая ам.долларын бондын эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгээр 2013 оны жилийн эцсийн байдлаар 563.8 тэрбум төгрөг бүхий төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн байна. Хөгжлийн банкнаас авах дотоод өрийн үлдэгдлийг шинээр гаргах баталгааны 15 хувьтай тэнцэх хэмжээгээр жил бүр нэмэгдэнэ гэсэн тооцоололтой байна.

4. Засгийн газрын гадаад үнэт цаасны өр

Монгол Улсын Засгийн газар 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 10 жилийн хугацаатай 1.0 тэрбум ам.долларыг 5.125 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай 0.5 тэрбум ам.долларын бондыг 4.125 хувийн хүүтэйгээр нийт 1.5 тэрбум ам.доллар буюу 2,481.2 /2013 оны жилийн эцсийн ханш/ тэрбум төгрөгийн бондыг олон улсын зах зээлд арилжсан. Энэхүү бондын эх үүсвэр нь Монгол Улсын дэд бүтцийг хөгжүүлэх, эдийн засгийн өндөр ач холбогдолтой, нэн тэргүүний хөрөнгө оруулалтад ашиглах үндсэн зорилготой бөгөөд 2014-2017 онд тус үнэт цаасны хүүгийн төлбөрт жилд дунджаар 114.5 тэрбум төгрөг төлөгдөхөөр байна.

5. Татварын урьдчилгаа төлбөр

Оюу толгойн урьдчилгаа төлбөрийн хүрээнд 2009 оны 10 дугаар сард Засгийн газрын үнэт цаасны гэрээ байгуулах замаар 3 хувийн хүүтэй 100.0 сая ам.долларыг 2014 онд эргэн төлөх нөхцөлтэйгээр, 2010-2011 онуудад урьдчилгаа төлбөрийн гэрээ байгуулах замаар 1.59 хувийн хүүтэй нийт 150.0 сая ам.долларыг 2013-2015 онуудад эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тус тус авч ашигласан.

Засгийн газрын зүгээс “Эрдэнэс тавантолгой” ТӨХК-аас авсан татварын урьдчилгаа төлбөрийн өрийн үлдэгдэл 2013 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 363.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд Оюу толгой, Эрдэнэс таван толгойн татварын урьдчилгаа төлбөрийн өрийн үлдэгдэл 2016 он гэхэд бүрэн төлөгдөж дуусах төсөөлөлтэй байна.

Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангах байдал

Засгийн газрын зүгээс олон улсын зах зээлд хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаас гаргалгүйгээр санхүүжилтийн эх үүсвэрийг аль болох дотоодын зах зээлд үнэт цаас арилжих замаар татан төвлөрүүлнэ гэж үзвэл 2014 онд Засгийн газрын өрийн үлдэгдэл /оны үнээр/ 10,245.9 тэрбум төгрөгтэй тэнцэхээр байгаа ба Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2014 онд 48.3 хувь, 2015 онд 45.6 хувь, 2016 онд 41.4 хувь, 2017 онд 38.5 хувь тус тус болохоор байна. Энэ нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг дээрх онуудад хангахаар тооцоололтой байна.

Уг тооцооллын хүрээнд дахин санхүүжилт, төсвийн алдагдлын зориулалтаар гаргах Засгийн газрын үнэт цаас болон гадаад зээлээс бусад шинээр үүсгэх зээллэгийн дээд хэмжээ 2014 онд 4,603.5 тэрбум төгрөг, 2015 онд 1,378.7 тэрбум төгрөг, 2016 онд 1,908.2 тэрбум төгрөг, 2017 онд 1,674.0 тэрбум төгрөг байхаар төсөөлөгдөж байна.

Засгийн газрын өрийн баталгаа, түүний хязгаарын тооцоолол

Өнөөг хүртэл гаргаад буй Засгийн газрын баталгаан дээр нэмээд ирэх онуудад шинээр гаргах баталгааны дээд хэмжээ 2014 онд 1,784.4 тэрбум төгрөг, 2015 онд 757.2 тэрбум төгрөг, 2016 онд 690.7 тэрбум төгрөг, 2017 онд 1,507.1 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэхээр байна.

Хүснэгт. Засгийн газрын баталгаа /тэрбум төгрөг/

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн ДНБ-д	2014	2015	2016	2017
---	-------------	-------------	-------------	-------------

ЭЗЛЭХ ХЯЗГААР	20.0%	20.0%	20.0%	20.0%
Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл	2,458.2	2,356.6	2,295.0	1,337.8
Засгийн газрын өрийн баталгааны ДНБ-д эзлэх хэмжээ	11.6%	9.6%	8.3%	4.4%

5.5 БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР, ТҮҮНИЙ ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭ

Засгийн газрын зүгээс 2014 оны 4 дүгээр сарын байдлаар дараах баталгааг гаргасан байна.

Хүснэгт. Засгийн газрын баталгааны хэмжээ

№	Баталгаа гаргуулагч	Гаргасан огноо	Өрийн хэмжээ
1	Хөгжлийн банк /гадаад үнэт цаас/	2012	580.0 сая.ам доллар
2	МИАТ ТӨХК-ийн АНУ-аас авсан зээл	2013	121.4 сая ам.доллар
3	Хөгжлийн банк /Самурай бонд/	2014	30.0 тэрбум иен

Дээрх Засгийн газрын өрийн баталгаан дээр нэмээд Хөгжлийн банкны Швейцарийн Credit Suisse банкнаас авах 300.0 сая ам.долларын зээл болон БНХАУ-аас авах 162.0 сая ам.долларын зээлд баталгаа гаргахаар шийдвэрлээд байна.

Засгийн газрын өрийн баталгаа гаргасан болон баталгаа гаргахаар шийдвэрлээд байгаад зээлүүдийг оруулж тооцвол Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2014 онд 2,458.2 тэрбум төгрөгтэй тэнцэхээр байгаа бөгөөд 2015 онд 2,356.6 тэрбум төгрөг, 2016 онд 2,295.0 тэрбум төгрөг, 2017 онд 1,337.8 тэрбум төгрөг /2017 онд Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын бонд төлөгдсөнөөр/ тус тус болохоор байна.

5.6 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ

Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийг тооцон гаргахад 2015 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,201.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 29.4 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлага 7,690.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.4 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 489.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэхээр байгаа бол 2016 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,322.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 26.5 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлага 7,874.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 28.5 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 552.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь, 2017 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,793.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 25.6 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлага 8,400.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.6 хувь, нэгдсэн төсвийн нийт алдагдал 607.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэхээр байна.

6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦСЭН БАЙДАЛ

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дунд хугацаанд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төрөөс баримтлах төсвийн бодлогын баримт бичиг юм. Энэхүү бодлогын баримт бичиг нь Төсвийн ерөнхийлөн захирагчдийн 2015 оны төсвийн хязгаар болон Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх болно.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн гол зорилго нь урт хугацаанд макро-эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг дэмжихэд чиглэгдэж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг баримтлан Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, дүн шинжилгээний хамт боловсрууллаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна. Үүнд:


- 1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.** Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцлоо.
- 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн оны төсвийн жилийн ДНБ-ий 2.0 хувиас илүүгүй алдагдалтай эсхүл ашигтай байх.** Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөллийг 2015, 2016, 2017 онуудад ДНБ-ий 29.4, 26.5, 25.6 хувь байх тооцоололд үндэслэн төсвийн нийт зарлагыг ДНБ-ий 31.4, 28.5, 27.6 хувь байхаар тус тус төсөөлж байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2015-2017 онуудад ДНБ-ий 2.0 хувьд байлгах зорилго тавьж байна.
- 3. Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.** Эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 2015 онд 14.8 хувь, 2016 онд 13.5 хувь, 2017 онд 11.5 хувь байхаар төсөөлж байна. Өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 2015 онд 23.4 хувь, 2016-2017 онд 23.4-22.7 хувь байх төлөвтэй байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 2015-2017 онд жилд дунджаар 4.8 хувь байхаар төлөвлөж байна.
- 4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан Улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т “энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг хөгжлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн бодит хэрэгцээ, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтаас төсөвт оруулах орлого, тэдгээр орд ашиглалтын урьдчилгаа төлбөрийн боломж, өмнөх жилүүдэд авч ашигласан гадаад зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай уялдуулж, үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор улсын нийт өрийн өнөөгийн цэвэр үнэ цэнээр илэрхийлсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2011 оны төсвийн жилд 50 хувиас, 2012 оны төсвийн жилд 60 хувиас, 2013 оны төсвийн жилд 50 хувиас, 2014 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газраар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барихыг дэмжээд буй Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн хязгаарт өөрчлөлт

оруулахаар тусгаад байна. Өрийн удирдлагын тухай хуулийн төслийн хүрээнд Засгийн газрын өрийн хэмжээ 2015-2017 онуудад 70 хувийн хязгаараас хэтрэхээргүй байна.

7. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ТӨСВИЙН БОДЛОГЫН НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААР ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эдийн засаг дахь төрийн оролцоо 40 орчим хувьтай байгаа өнөөгийн нөхцөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тэнцвэрт төсвийн бодлого голлох нөлөө үзүүлж байна. Энэ нөхцөлд төсвийн тогтвортой байдлыг хангах нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах гол баталгаа болохоор байна.


График. Төсвийн орлого, зарлагын хэмжээ



2013 оны байдлаар нэгдсэн төсвийн нийт зардал ДНБ-ий 35.2 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий 33.5 хувьтай тэнцэж байна.

Олон улсын түвшинд макро эдийн засгийн тогтвортой байдлыг инфляци, валютын ханш, эдийн засгийн өсөлт, гадаад өрийн хэмжээ зэрэг голлох үзүүлэлтээр хэмждэг. Эдгээр үзүүлэлтүүд болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг доорх графикт үзүүлэв.


График. Эдийн засгийн өсөлт болон төсвийн орлого, зарлагын өсөлт



Төсвийн орлого, зарлагын өсөлт эдийн засгийн өсөлттэй ижил чиглэлд явж ирсэн байна. Гадаад эдийн засгийн нөхцөл байдал таатай байсан 2006-2007 онуудад төсвийн орлого, зарлага огцом нэмэгдэж байсан бөгөөд улмаар 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын жилүүдэд эдийн засгийн өсөлт, төсвийн орлогод


бууралт ажиглагдаж 2009 онд эдийн засгийн бууралт бий болоход төсвийн орлого буурч, зарлага хумигдсан. 2010-2011 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр төсвийн орлого, зарлага ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн. Харин 2012-2013 онд төсвийн орлогын өсөлтийн хурд буурсан.

График. Инфляци болон төсвийн зарлагын өсөлт



2007 оны сүүлчийн хагасаас дэлхийн хүнсний хямрал, 2008 оны сүүлчээс дэлхийн санхүүгийн хямрал зэрэг үйл явдлууд дараалан гарч ирснээр инфляци өсч 22.1 хувьд хүрч байсан. Төсвийн зөөлөн бодлого эрэлтээс үүдэлтэй инфляцийн шалтгаан болдог боловч манай улсын хувьд төсвийн бодлогоос илүүтэйгээр нийлүүлэлтийн талын нөлөө инфляцид хүчтэй нөлөө үзүүлдэг.

График. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш болон төсвийн зарлагын өсөлт



Төсвийн зарлагын өсөлт болон валютын ханшийн өөрчлөлтийн хамаарал тухайн жил манай улсад орж ирэх валютын урсгалын хэмжээнээс ихээхэн хамаардаг. Тухайлбал, валютын орох урсгал нэмэгдэх нь төсвийн орлогыг өсгөх нөлөө үзүүлж, улмаар зарлагын өсөлтийг бий болгодог. Валютын орох урсгал их хэмжээтэй үед төсвийн зарлага өсөх нь валютын ханшийг сулруулах нөлөө үзүүлдэггүй бөгөөд эсрэгээрээ ханш чангарах нөлөөг үзүүлдэг гэж үзэж болохоор байна.


Сүүлийн жилүүдэд Төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлд хийсэн томоохон ажил бол 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, 2011 оноос хэсэгчилсэн байдлаар, 2013 оноос бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж буй явдал юм.

Макро эдийн засгийн тогворжуулалтыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын хууль эрх зүйн шинэ орчин бий болгосноор эдийн засгийн хямралын ба өндөр өсөлтийн аль алинд нь төсвийн тогтвортой байдал хадгалагдаж байх бөгөөд эдийн засгийн хэвийн нөхцөлд төсөв тогтвортой байж, хямралын нөхцөлд төсвөөр бодит

сектор, санхүүгийн системийг хөхүүлэн дэмждэг шинэ зарчимд шилжих зэрэг ач холбогдолтой юм.

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндэсний хуримтлалыг үүсгэсэн: Ашигт малтмалын үнийн савалгаанаас хэт хараат байдаг манай улсын хувьд төсвийн хувьд тогтворгүй байдал үүссэн нөхцөлд төсөв тогтворжуулах үндэсний санхүүгийн хуримтлалгүйгээс төсвийн алдагдал нэмэгдэх, нийгэм, эдийн засгийн салбар, улсын хөрөнгө оруулалтын зэрэг уламжлалт санхүүжилтийг огцом хасах шаардлага гарч, энэ нь иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх, улмаар макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал үүсэх эрсдэл өндөр байдаг. Энэхүү эрсдэлээс сэргийлэх үүднээс 2011 оноос эхлэн төсвийн тогтворжуулалтын санг үүсгэн үндэсний санхүүгийн хуримтлал үүсгэж байна.


График. Төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлал, тэрбум төгрөг



Төсвийн тогтворжуулалтын санд 2013 оны жилийн эцсийн байдлаар 382.5 тэрбум төгрөг хуримтлагдаад байна. Энэхүү сангийн хөрөнгө нь гол нэр төрлийн эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнэ огцом унах үед төсвийн мөчлөг дагасан бодлого явуулахаас сэргийлэх, төлөвлөсөн зарцуулалтыг үргэлжлүүлэн хийх, төсвийн бодлогын тогтвортой байдлыг хангахад ашиглагдах юм. 2015-2017 онд төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох төсвийн тусгай шаардлага үргэлжлэн хэрэгжих бөгөөд энэхүү механизм нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөөлөл үзүүлж, төсвийн тогтворжуулалтын гол арга хэрэгсэл байх болно.

Төсвийн алдагдлын хэмжээг огцом бууруулж, тэнцвэржүүлсэн төсвийн бодлогод шилжсэн: Манай улсын хувьд 2011, 2012 онд төсвийн алдагдлын хэмжээ хэт өндөр байсан бөгөөд 2013 онд төсвийн алдагдлыг ДНБ-ий 1.7 хувьд хүргэсэн.

График. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөг



2013 оноос Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн тусгай шаардлага хэрэгжиж эхэлсэн бөгөөд төсвийн тогтвортой байдал, улмаар макро эдийн засаг дахь төрийн зохистой оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх юм. Улмаар 2015-2017 онд төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй байх

төсвийн бодлого хэрэгжүүлснээр макро эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөөлөл үзүүлэх юм.

Зарлагын талаарх тусгай шаардлагаар тухайн жилд зарлага нэмэгдүүлэх дээд түвшинд хязгаар тогтоох, ингэснээр макро эдийн засгийн эрэлт хэрэгцээний удирдлагад хоёр дахь шалгуур тогтоож өгч байна. Засгийн газрын бараа, үйлчилгээний өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, инфляцид нөлөөлж, валютын ханшийг хэт хөөрөгдүүлэхгүйгээр хангах, эдийн засгийн эдгээр зарлагыг шингээх чадавхитай уялдан нийцэх түвшинд л зарлагын өсөлтийн энэ тусгай шаардлага хязгаарлах учиртай.

Энэхүү тусгай шаардлагын дагуу нэгдсэн төсвийн зарлага нь эдийн засгийн өсөлтийн хувиас хэтрэхгүйгээр өсдөг байх ёстой. Ингэснээр сангийн бодлого эдийн засгийн мөчлөгийг дагасан биш мөчлөгийн эсрэг байдлаар явах болсныг илтгэж байгаа юм. Үүний гол жишээ нь 2006-2008 онуудад эдийн засгийн өсөлтийг дагасан сангийн бодлого буюу төсвийн зарлагын хэт өсөлт нь дэлхийн санхүүгийн хямрал нүүрлэсэн 2009 онд төсвөөр дамжуулж эдийн засгийг дэмжих хангалттай санхүүгийн эх үүсвэргүй болоход нөлөөлсөн явдал юм. Тиймээс ирэх жилүүдэд төсвийн зарлагыг зохистой түвшинд хүртэл өсгөх бодлогыг баримтална.

Өрийн хэмжээ тогтвортой байна: Улсын өрийн тусгай шаардлага нь улсын өрийн ил тод зураглалыг харуулж олон улсын хөрөнгийн зах зээлд төсвийн тогтвортой байдлын сигналыг өгөх утгаараа түүний үүрэг чухал юм. Тиймээс 2015-2017 онд улсын өрийн хэмжээг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байх төсвийн бодлого баримталж, макро эдийн засгийн тэнцвэрт байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

8. ДУНД ХУГАЦААНД ТӨСӨВТ УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

Дунд хугацаанд төсвийн бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэхэд дараах эрсдэлүүд учирч болзошгүй байна. Үүнд:

1. БНХАУ-ын эдийн засгаас хамааралтай байдал, цөөн тооны экспортын бүтээгдэхүүн: Манай улсын гол экспортлогч улс болох БНХАУ-ын эдийн засгийн байдал, ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж уул уурхайн салбараас орох төсвийн орлого ихээхэн хамааралтай байгаа нь гол эрсдэлийг учруулж болзошгүй байна. ОУВС-ын зүгээс 2015 онд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 7.3 хувь болж 2014 оны түвшинээс буурахаар байгаа нь Монгол улсын эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлж болох юм.

БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, нүүрс, зэс, төмрийн хүдрийн зах зээлийн нөхцөл байдлыг сайтар ажиглаж, тус улсын эдийн засгийн сөрөг нөлөөллөөс үүдэлтэй дарамтаас сэргийлэхийн тулд дотоодын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бусад эрдсийн экспортыг нэмэгдүүлж, экспортын багцыг төрөлжүүлэх шаардлагатай байна.

2. Гадаадын хөрөнгө оруулалтаас хэт хамааралтай байх: Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оноос огцом буурсан бөгөөд 2013 оны Оюу Толгой төслийн гэрээ хэлэлцээр удааширсан явдал, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн анхны хувилбар зэрэг нь Монгол улсын хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлсөн. ОУВС-ийн төсөөллийн дагуу (2013 оны 11 дүгээр сар) хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын хувьд дэлхийн санхүүгийн зах зээл, экспортын бүтээгдэхүүний зах зээлийн

тодорхой бус байдал өндөр түвшинд байгаатай холбоотойгоор хөгжиж буй улсуудад хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах хандлагатай байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулинд оруулсан эерэг өөрчлөлтүүдийг гадны улсуудад сурталчлах, Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын асуудлыг яаралтай шийдвэрлэх нь эерэг нөлөөлөл үзүүлэх юм.

3. Төлбөрийн тэнцлийн алдагдал, валютын ханшны бууралт: 2013 онд Оюу Толгой төслийн эхний шатны хөрөнгө оруулалт дууссан болоод хөрөнгө оруулалтын орчны тогтворгүй байдалтай холбоотойгоор Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 55 хувиар буурсан нь санхүүгийн дансны ашиг буурахад нөлөөлсөн байна. Ийнхүү хөрөнгө оруулалт буурсан нь валютын зах дээрх гадаад валютын нийлүүлэлтийг бууруулж, улмаар төлбөрийн тэнцэлд дарамт үүсгэн, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад нөлөөлсөн суурь хүчин зүйл болсон. Төсвийн тэлэх бодлого, мөнгөний зөөлөн бодлого зэрэг нь Оюу Толгойн төслийн эхний үе шат дууссаны дараа импортын эрэлтийг өндөр байлгасаар байна.

Импортын дарамтыг бууруулах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлээс эх үүсвэр татах ажлыг эрчимжүүлэх шаардлага байна.

9. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХОД ХЭРЭГЛЭСЭН АРГАЧЛАЛ, ТООЦООНЫ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын 2015 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийг боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, түүнийг тооцоход ашигласан аргачлалын талаар дор товч тайлбарлав.

Хүснэгт. Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцоход хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт	Хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл
Эдийн засгийн төсөөлөл	
1. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл	Төсвийн хүрээний мэдэгдэлд ашигласан макро үзүүлэлтүүд болох бодит ба нэрлэсэн ДНБ, инфляци, валютын ханш, экспорт, импорт, ажилгүйдлийн түвшин зэргийг Эдийн засгийн хөгжлийн яамнаас боловсруулан ирүүлсэн бөгөөд уг үзүүлэлтүүдийг тооцоходоо эконометрикийн загварууд болон санхүүгийн програмчлалын загварыг ашигладаг.
Төсвийн орлогын төсөөлөл	
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төсөөлөл	Төсөөлсөн үнэ болон тоо хэмжээний үржвэрээс уг орлогыг тооцоолон гаргадаг. Үндсэн хоёр экспортын бүтээгдэхүүн болох зэс, нүүрс (нийт орлогын 3% -аас илүү хувийг бүрдүүлдэг)-ний зах зээлийн үнэ, тэнцвэржүүлсэн үнийг ашиглан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3 –т заасан томъёогоор зэс, нүүрснээс төвлөрөх орлогыг бодож гаргасан. Тэнцвэржүүлсэн үнэ гэдэг нь өмнөх 12 жилийн

	дундаж бай ирэх 3 жилийн дундаж хоёрын дундаж юм. Экспортын хэмжээг Уул уурхайн яамнаас тодорхойлон ирүүлсэн. Зах зээлийн үнээр тооцсон орлого, тэнцвэржүүлсэн үнээр тооцсон орлого хоорондын зөрүүг Тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцсон.
3. Хувь хүний орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төсөөлөл	Нэрлэсэн ДНБ-ийг татварын суурь болгон, өмнөх онуудын гүйцэтгэл, ирээдүйн хандлагыг харгалзан төсөөллийг гаргасан.
4. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын төсөөлөл	ДНБ-ийг татварын суурь болгодгоос гадна импортын түвшинг давхар харгалзан үзэж төсөөллийг гаргасан.
5. Төлбөр, хураамжийн орлогын төсөөлөл	Төлбөр тус бүрийн хэмжээг яамдаас авсан мэдээлэл, хандлагын дагуу тодорхойлсон.
6. Онцгой албан татварын орлогын төсөөлөл	Онцгой албан татвар ногдуулдаг импортын болон дотоодод үйлдвэрлэдэг барааны тоо хэмжээний төсөөллийг хуулинд заасан хувь хэмжээ болон валютын ханшаар үржүүлэн тооцдог. Харин автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг УИХ-аас баталсан хязгаарт багтаан Засгийн газар тогтоож байхаар эрх олгосон тул Засгийн газраас баталсан хувь хэмжээг баримтлан тооцсон болно.
7. Гаалийн албан татварын орлогын төсөөлөл	Эдийн засгийн хөгжлийн яам нь өөрийн чиг үүргийн хүрээнд валютын ханш, экспорт, импортыг хэмжээг тооцон ирүүлдэг болно. Тус яамнаас нийт импортын хэмжээнд эзлэх татвартай импортын хэмжээг тодорхойлж гаалийн албан татварын хувь хэмжээнд уялдуулан тооцдог болно.
Төсвийн зарлагын төсөөлөл	
8. Төсвийн урсгал зарлагын төсөөлөл	Цалин, тэтгэврийн хэмжээг ЭЗХЯ-аас ирүүлсэн инфляцийн түвшинтэй ижил хэмжээнд өсгөн тооцсон бөгөөд бусад урсгал зардлыг 2014 оны батлагдсан түвшинд байхаар тооцсон.
9. Төсвийн хөрөнгийн зарлагын төсөөлөл	2014 онд хийгдэж буй хөрөнгө оруулалтын 2015 онд дамжин хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлж, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын дүнг нэмэх замаар тооцсон.